МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 11 өдөр Дугаар А/612. Алтай хот

# Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх ХУР систем төслийн хүрээнд Баян-Уул, Жаргалан, Халиун, Цээл, Тонхил, Бигэр сумдад суурилуулсан 20 метр өндөртэй харилцаа холбооны цамхагийн угсралт, суурилуулалтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга | Б.Бямбадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор) |
| Гишүүд | М.Мандаххүү | (Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга) |
| | З.Жаргалтуяа | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ц.Амарсанаа | (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч хошууч) |
| | А.Оюун-Эрдэнэ | (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч) |
| | Р.Пүрэвдорж | (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн) |
| | Н.Чулуунчимэг | (Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн) |
| | Ч.Отгон | (Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн) |
| | Д.Цэвэлмаа | ("Мэдээлэл харилцаа холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер) |
| | С.Цэмбэлдорж | ("Эрчим төсөл" ХХК-ийн инженер зохиогч) |

З.Бат-Эрдэнэ (“Эйч Ти Эл” ХХК-ийн инженер гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг холбогдох, хууль журмын дагуу бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн цаашдын ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, урсгал зардлыг төсөвт тусгаж ажиллахыг "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК (Б.Жаргалсайхан)-нд тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/144 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ